



**ХЭНТИЙ АЙМГИЙН
ДАДАЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2025 оны 03 сарын 27 өдөр

Дугаар 137

Дадал сум

Түр цугларах аюулгүйн талбай, нүүлгэн
шилжүүлэх газар, нисэх буух талбай тогтоох
тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, 59 дүгээр зүйлийн 59.1.21, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.3 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Гамшиг, аюулт үзэгдэл, ослын үед сумын нийт хүн амыг нүүлгэн шилжүүлэх талбайг Балж багийн нутаг Сөөгтэй (өргөрөг 49°01'28"N, уртраг 111°31'53"E), түр цугларах аюулгүйн талбайг Соёлын төвийн гадна талбай, Спорт цогцолборын гадна талбайд, онгоц нисэх буух талбайг "Дэлүүн болдог" нисэх онгоцны буудал, наадмын талбайн урд талд байхаар баталсугай.

2. Түр цугларах аюулгүйн талбайг тэмдэгжүүлж, нисэх буух талбай, нүүлгэн шилжүүлэх газрыг зургаар баталгаажуулан төлөвлөгөөнд тусгахыг мэргэжлийн ангийн дарга (Ж.Хоридой), онцгой комиссын нарийн бичгийн дарга (Д.Гэрэлмаа) нарт тус тус үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Ш.МӨНХХУЯГ

010000117